**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2025/042/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өмнөговь аймаг 2025 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитор: Э.Жаргал
Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 166
танай ____________-ны №____________ -т

ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
О.НАМЖИЛМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ..

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 34,480.0 мянган төгрөг зориулалт бусаар зарцуулсан, тайланд тусгасан 122,140.6 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн бүртгэлийг баталгаажуулаагүй, албан хаагчдад 9,908.8 мянган төгрөгийн дэмжлэг олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.5, 12 дугаар зүйлийн 12.2.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2, 21 дүгээр зүйлийн 21.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралт "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2, Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 дугаар тоот тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын 2 дахь хэсгийн 9-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

4625020367
F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар киоск машиныг байршуулан ашиглаж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Ханбогд хөгжлийн хурдасгуур оюу толгой сангийн хөрөнгө оруулалтаар 8,629,888.0 мянган төгрөгийн "Галба" нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлэг, тохижилтын ажил хийгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 77 арга хэмжээг хэрэгжүүлэн 84.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **33** | **АВЛАГА** | - | 26,227,345.04 |
| **335** | **Бусад авлага** | - | 26,227,345.04 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 1,260,138.74 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 24,967,206.30 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,191,809,306.03 | 1,154,588,457.95 |
| **351** | **Түүхий эд материал** | 793,521,028.00 | 1,032,447,814.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 793,521,028.00 | 1,032,447,814.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 398,288,278.03 | 122,140,643.95 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 50,000.00 | 50,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,865,950.00 | 40,672,070.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 387,372,328.03 | 81,418,573.95 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 3,165,558,287.00 | 44,680,810,103.80 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 3,165,558,287.00 | 44,680,810,103.80 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **37,142,711,675.81** | **58,578,143,691.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 37,142,711,675.81 | 58,578,143,691.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 33,299,197,592.48 | 54,736,653,358.07 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 15,904,358,162.48 | 22,064,423,665.48 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,581,878,940.84) | (1,861,291,120.88) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 672,625,000.00 | 831,565,750.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (121,279,354.24) | (192,515,373.07) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 564,050,745.00 | 743,746,136.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (84,496,629.21) | (179,447,377.45) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 202,128,338.56 | 223,858,856.56 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (87,998,715.30) | (118,630,552.17) |
| 39209 | Зам, гүүрний байгууламж | 1,588,277,209.00 | 1,588,277,209.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (145,592,077.40) | (225,005,937.80) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,890,092,354.67 | 36,441,767,398.67 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,521,073,070.24) | (4,600,079,867.20) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 19,984,570.00 | 19,984,570.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,843,514,083.33 | 3,841,490,333.10 |
| 39301 | Программ хангамж | 12,132,000.00 | 12,132,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,587,416.67) | (3,611,166.90) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,832,969,500.00 | 3,832,969,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **41,500,079,268.84** | **104,439,769,597.96** |
| **413** | **Өглөг** | 0.40 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.40 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **41,500,079,268.44** | **104,439,769,597.96** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 41,500,079,268.44 | 104,439,769,597.96 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,700,330,670.84 | 4,700,330,670.84 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,700,330,670.84 | 4,700,330,670.84 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 36,251,404,512.42 | 99,191,094,841.94 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 36,251,404,512.42 | 36,251,404,512.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 62,939,690,329.52 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 548,344,085.18 | 548,344,085.18 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **41,500,079,268.84** | **104,439,769,597.96** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **82,132,592,682.00** | **130,618,745,540.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,736,036,338.00** | **13,131,126,389.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,736,036,338.00 | 13,131,126,389.93 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 60,195,826.00 | 85,206,630.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,195,826.00 | 85,206,630.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **78,396,556,344.00** | **117,487,619,150.40** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 640,336,444.00 | 639,725,150.40 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,500,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 504,515,286.00 | 333,094,969.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 79,334,778.00 | 8,605,895.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 45,986,380.00 | 298,024,286.40 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 77,756,219,900.00 | 116,847,894,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 77,756,219,900.00 | 116,847,894,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **72,365,520,273.23** | **67,551,830,101.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **72,365,520,273.23** | **67,551,830,101.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,848,141,910.38 | 16,522,839,306.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 519,935,970.71 | 908,931,038.01 |
| 210101 | Үндсэн цалин | 287,909,316.13 | 455,370,500.96 |
| 210102 | Нэмэгдэл | 223,219,789.78 | 375,857,009.09 |
| 210104 | Урамшуулал | 8,806,864.80 | 77,703,527.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 67,217,799.00 | 115,199,357.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,918,484.25 | 78,092,718.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,381,753.18 | 9,479,500.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,260,762.94 | 7,525,315.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 835,690.24 | 2,020,055.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,821,108.39 | 18,081,767.30 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 188,954,142.44 | 251,372,071.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 151,498,856.44 | 153,363,149.40 |
| 210302 | Түлш, халаалт | 35,220,240.00 | 92,018,630.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,235,046.00 | 5,990,292.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,061,900,505.17 | 7,638,657,824.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,150,000.00 | 5,983,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 67,298,650.00 | 78,155,895.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,081,948.00 | 14,486,642.96 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 35,901,000.00 | 36,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 730,903,389.97 | 6,571,500.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 5,208,565,517.20 | 7,497,460,586.74 |
| **2105** | **Норматив зардал** | 178,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 178,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,759,910.00 | 26,692,230.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 724,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 20,035,910.00 | 26,692,230.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,264,000.00 | 25,850,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 10,264,000.00 | 25,850,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,377,934,599.00 | 5,686,638,652.71 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,377,934,599.00 | 5,686,638,652.71 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,600,996,984.06 | 1,869,498,132.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117,099,001.00 | 229,876,741.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,000,000.00 | 2,946,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,481,897,983.06 | 1,636,675,191.57 |
| **212** | **ТАТААС** | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 61,487,378,362.85 | 50,998,990,795.47 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 111,191,136.00 | 96,403,006.89 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 45,661,107.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 111,191,136.00 | 50,741,899.89 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 61,376,187,226.85 | 50,902,587,788.58 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 61,376,187,226.85 | 50,902,587,788.58 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **9,767,072,408.77** | **63,066,915,438.37** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 160,645,000.88 | 127,225,108.85 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 160,645,000.88 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 127,225,108.85 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (160,645,000.88) | (127,225,108.85) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **9,606,427,407.89** | **62,939,690,329.52** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **78,456,752,170.00** | **117,572,825,780.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **60,195,826.00** | **85,206,630.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 60,195,826.00 | 85,206,630.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 60,195,826.00 | 85,206,630.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,195,826.00 | 85,206,630.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **78,396,556,344.00** | **117,487,619,150.40** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 640,336,444.00 | 639,725,150.40 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,500,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 504,515,286.00 | 333,094,969.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 79,334,778.00 | 8,605,895.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 45,986,380.00 | 298,024,286.40 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 77,756,219,900.00 | 116,847,894,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 77,756,219,900.00 | 116,847,894,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **65,115,801,800.60** | **57,888,057,715.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **65,115,801,800.60** | **57,888,057,715.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,598,423,437.75** | **6,859,066,920.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 518,610,088.31 | 932,361,508.05 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 287,909,316.53 | 456,879,096.00 |
| 210102 | Нэмэгдэл | 221,893,906.98 | 397,778,884.05 |
| 210104 | Урамшуулал | 8,806,864.80 | 77,703,528.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 67,217,799.00 | 117,996,232.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,918,484.25 | 80,889,594.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,381,753.18 | 9,479,500.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,260,762.94 | 7,525,315.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 835,690.24 | 2,020,055.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,821,108.39 | 18,081,767.30 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 188,954,142.44 | 251,372,071.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 151,498,856.44 | 153,363,149.40 |
| 210302 | Түлш, халаалт | 35,220,240.00 | 92,018,630.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,235,046.00 | 5,990,292.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 130,740,298.00 | 141,713,737.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,150,000.00 | 5,983,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 67,298,650.00 | 78,155,895.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,081,948.00 | 14,486,642.96 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 35,901,000.00 | 36,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,308,700.00 | 7,088,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | 178,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 178,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,759,910.00 | 26,692,230.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 724,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 20,035,910.00 | 26,692,230.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,264,000.00 | 25,850,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,264,000.00 | 25,850,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,403,358,699.00 | 4,868,946,199.28 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,403,358,699.00 | 4,868,946,199.28 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 258,340,501.00 | 494,134,941.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 256,340,501.00 | 491,188,741.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,000,000.00 | 2,946,200.00 |
| **212** | **ТАТААС** | **30,000,000.00** | **30,000,000.00** |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,487,378,362.85** | **50,998,990,795.47** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 111,191,136.00 | 96,403,006.89 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 45,661,107.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 111,191,136.00 | 50,741,899.89 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 61,376,187,226.85 | 50,902,587,788.58 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 61,376,187,226.85 | 50,902,587,788.58 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **13,340,950,369.40** | **59,684,768,064.74** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **13,340,950,369.40** | **59,684,768,064.74** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **13,340,950,369.40** | **59,684,768,064.74** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 13,340,950,369.40 | 59,684,768,064.74 |
| 223001 | Бусад хөрөнгө | 8,288,171,282.40 | 49,258,907,711.74 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,052,779,087.00 | 10,425,860,353.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(13,340,950,369.40)** | **(59,684,768,064.74)** |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,700,330,670.84 | 548,344,085.18 | 36,251,404,512.42 | 41,500,079,268.44 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,700,330,670.84 | 548,344,085.18 | 36,251,404,512.42 | 41,500,079,268.44 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,700,330,670.84 | 548,344,085.18 | 36,251,404,512.42 | 41,500,079,268.44 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 62,939,690,329.52 | 62,939,690,329.52 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,700,330,670.84 | 548,344,085.18 | 99,191,094,841.94 | 104,439,769,597.96 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 116,867,894,000.00 | 66,115,392,443.93 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 8,210,667,600.00 | 6,593,710,387.39 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 8,124,487,400.00 | 6,508,140,480.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 911,938,500.00 | 854,657,980.05 |
| 210101 | Үндсэн цалин | 474,560,100.00 | 456,879,096.00 |
| 210102 | Нэмэгдэл | 437,378,400.00 | 397,778,884.05 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,325,800.00 | 109,548,548.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,848,300.00 | 75,262,177.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,119,400.00 | 8,774,299.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,295,500.00 | 6,114,909.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,823,800.00 | 1,707,504.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,238,800.00 | 17,689,658.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 325,005,500.00 | 251,372,071.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 217,860,400.00 | 153,363,149.40 |
| 210302 | Түлш, халаалт | 99,495,100.00 | 92,018,630.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,650,000.00 | 5,990,292.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 144,536,000.00 | 136,457,842.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,000,000.00 | 5,983,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 72,900,000.00 | 72,900,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 22,336,000.00 | 14,486,642.96 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 36,000,000.00 | 36,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,300,000.00 | 7,088,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 200,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,700,000.00 | 34,675,930.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,000,000.00 | 7,983,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 26,700,000.00 | 26,692,230.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,400,781,600.00 | 5,024,048,507.48 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,378,660,400.00 | 5,024,048,507.48 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 22,121,200.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 165,000,000.00 | 72,379,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 162,000,000.00 | 69,433,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 2,946,200.00 |
| **212** | **ТАТААС** | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 56,180,200.00 | 55,569,907.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 56,180,200.00 | 55,569,907.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,680,200.00 | 45,661,107.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,500,000.00 | 9,908,800.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **108,657,226,400.00** | **59,521,682,056.54** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 108,657,226,400.00 | 59,521,682,056.54 |
| 223001 | Бусад хөрөнгө | 108,657,226,400.00 | 59,521,682,056.54 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 116,867,894,000.00 | 66,115,392,443.93 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 116,847,894,000.00 | 66,030,185,813.93 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 116,847,894,000.00 | 66,030,185,813.93 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 20,000,000.00 | 85,206,630.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,000,000.00 | 85,206,630.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

### 2.5.1 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **639,725,150.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **639,725,150.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 514,012,448.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 77,703,528.00 |
| 210104 | Урамшуулал | 77,703,528.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8,447,684.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,627,417.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 705,201.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,410,406.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 312,550.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 392,109.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,255,895.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,255,895.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 850,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 850,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 421,755,341.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 421,755,341.00 |

| | | |
|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 40,833,099.89 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 40,833,099.89 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 40,833,099.89 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **84,879,602.51** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 84,879,602.51 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 639,725,150.40 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 639,725,150.40 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 333,094,969.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,605,895.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 298,024,286.40 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 202,109.4 мянган төгрөгийн 12 алдаа[1] илэрснээс аудитын явцад 202,109.4 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 25,654.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 49,258.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлын дүнг санхүүгийн үр тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 527.9 мянган төгрөгийн дутуу тайлагнасан,
- Өглөгийн тодруулга тайлангийн гэрэл цахилгааны дүн мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардлын дүнгээс 4,336.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Өглөгийн тодруулга тайлангийн түлш халаалтын өглөгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардлын дүнгээс 9,145.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Өглөгийн тодруулга тайлангийн шуудан холбооны дүн мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардлаас 752.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын дүнг санхүүгийн үр тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 500.0 мянган төгрөгийн дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн урсгал засварын зардлын дүнг санхүүгийн үр тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 538.6 мянган төгрөгийн дутуу тайлагнасан,
- Нэмэлт санхүүжилтийн тайлангийн төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын дүнг уг дансны хуулгатай тулган баталгаажуулахад 84,8796 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Тайлант онд 24,967.2 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан,
- Тайлант онд 1,260.1 мянган төгрөгийн НДШ-ын авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан,
- Өглөгийн тодруулга тайлангийн албан томилолтын дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардлын дүнгээс 288.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 1, Нягтлан бодох

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 202,109.4 мянган төгрөгөөр залруулав.
Аудитаар 5 зөрчил[2] илэрсэнд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага , 1 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

*<u>Илрүүлэлт-1</u>:* Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдад 9,908.8 мянган төгрөгийн дэмжлэг олгохдоо 990.8 мянган хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,...", Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралт "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-д "Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй “Хөдөлмөрийн дотоод журам” зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй" гэж заасантай нийцээгүй байна.

*<u>Илрүүлэлт-2:</u>* Төсвийн хөрөнгөөр 285.0 мянган төгрөгөөр нэрмэл архи худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Дээрх зөрчлүүдэд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу төлбөрийн акт тогтоох

### 3.2 Албан шаардлага

Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал:

*<u>Илрүүлэлт-1</u>:* Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2,750.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 дугаар тоот тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын 2 дах хэсгийн 9-д "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан олгосон хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулах уг хөрөнгө олгогдоогүй байхад урьдчилан зардал гаргахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*<u>Илрүүлэлт-2</u>:* Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас сумын цагдаагийн тасагт 26,400.0 мянган төгрөгийн шатахуун, 5,330.0 мянган төгрөгийг дууны тэмцээний шагналд олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 дугаар тоот тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын 2 дах хэсгийн 9-д "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан олгосон хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулах уг хөрөнгө олгогдоогүй байхад урьдчилан зардал гаргахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*__Шийдвэрлэсэн нь :__* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*__Илрүүлэлт-3:__* Тайлант тусгасан 122,140.6 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй байна.

Энэ нь УСНБББОУС-12 бараа материал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцээгүй байна.

*__Шийдвэрлэсэн нь :__* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

*__Илрүүлэлт-1:__* Байгууллагын даргын 2024 оны А/89 дугаар тушаалаар баталсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооллогын үр дүнгийн тайланг тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 "Тооллогын комисс дараах үүрэгтэй", 4 "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцээгүй байна.

*__Өгсөн зөвлөмж__*: Эд хөрөнгийн тооллогын комиссын ажлын үр дүнг сайжруулан, хөрөнгийн хяналт, хадгалалт, хамгаалалтыг дээшлүүлэн ажиллах

*__Илрүүлэлт-2__* Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ",14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*__Өгсөн зөвлөмж__*: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган цахим дэлгүүрээс худалдан авалт хийж хэвших зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 25,654.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 25,654.1 | | | 1 | 25,654.1 | 1 | 25,654.1 | - | - | - | - |
| 2 | Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 49,258.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 49,258.9 | | | 1 | 49,258.9 | 1 | 49,258.9 | | | | |
| 3 | Мөнгөн гүйлгээний тайлангийн бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлын дүнг санхүүгийн үр тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 527.9 мянган төгрөгийн дутуу тайлагнасан | 1 | 527.9 | | | 1 | 527.9 | 1 | 527.9 | | | | |
| 4 | Өглөгийн тодруулга тайлангийн гэрэл цахилгааны дүн мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардлын дүнгээс 4,336.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 4,336.6 | | | 1 | 4,336.6 | 1 | 4,336.6 | | | | |
| 5 | Өглөгийн тодруулга тайлангийн түлш халаалтын өглөгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардлын дүнгээс 9,145.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 9,145.3 | | | 1 | 9,145.3 | 1 | 9,145.3 | | | | |
| 6 | Өглөгийн тодруулга тайлангийн шуудан холбооны дүн мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардлаас 752.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 753.0 | | | 1 | 753.0 | 1 | 753.0 | | | | |
| 7 | Мөнгөн гүйлгээний тайлангийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын дүнг санхүүгийн үр тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 500.0 мянган төгрөгийн дутуу тайлагнасан | 1 | 500.0 | | | 1 | 500.0 | 1 | 500.0 | | | | |
| 8 | Мөнгөн гүйлгээний тайлангийн урсгал засварын зардлын дүнг санхүүгийн үр тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 538.6 мянган төгрөгийн дутуу тайлагнасан | 1 | 538.6 | | | 1 | 538.6 | 1 | 538.6 | | | | |
| 9 | Нэмэлт санхүүжилтийн тайлангийн төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын дүнг уг дансны хуулгатай | 1 | 84,879.6 | | | 1 | 84,879.6 | 1 | 84,879.6 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тулган баталгаажуулахад 84,8796 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | | | | | | | | | | | | |
| 10 | Тайлант онд 24,967.2 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан | 1 | 24,967.2 | | | 1 | 24,967.2 | 1 | 24,967.2 | | | | |
| 11 | Тайлант онд 1,260.1 мянган төгрөгийн НДШ-ын авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан | 1 | 1,260.1 | | | 1 | 1,260.1 | 1 | 1,260.1 | | | | |
| 12 | Өглөгийн тодруулга тайлангийн албан томилолтын дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардлын дүнгээс 288.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 288.00 | | | 1 | 288.00 | 1 | 288.00 | | | | |
| | Дүн | **12** | **202,109.4** | **-** | **-** | **12** | **202,109.4** | **12** | **202,109.4** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Байгууллагын даргын 2024 оны А/89 дугаар тушаалаар баталсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооллогын үр дүнгийн тайланг тайлагнаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 2 | Тайлант тусгасан 122,140.6 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй байна. | 1 | 122,140.6 | | | 1 | 122,140.6 | | | | | | |
| 3 | Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдад 9,908.8 мянган төгрөгийн дэмжлэг олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй. | 1 | 990.8 | 1 | 990.8 | | | | | | | | |
| 4 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2,750.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг олгосон | 1 | 2,750.0 | | | 1 | 2,750.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас сумын цагдаагийн тасагт 26,400.0 мянган төгрөгийн шатахуун, 5,330.0 мянган төгрөгийг дууны тэмцээний шагналд олгосон байна. | 1 | 31,730.0 | | | | 31,730.0 | | | | | | |
| | **Дүн** | **5** | **157,611.4** | **1** | **990.8** | **2** | **156,620.6** | **1** | **-** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Төсвийн хөрөнгөөр 285.0 мянган төгрөгөөр нэрмэл архи худалдан авсан | 1 | 285.0 | 1 | 285.0 | | | | |
| 2 | Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| 3 | Шилэн дансны нэгдсэн системд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээллийг байршуулаагүй. | 1 | 0 | | | 1 | - | | |
| 4 | Шилэн дансны нэгдсэн системд 171 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. | 1 | 0 | | | | - | | |
| | **Дүн** | **4** | **285.0** | **1** | **285.0** | **1** | **-** | **1** | **-** |